

буурсантай холбоотой гэж бид үзэж байна. Одоо Цойцон нуур гэж ярих боловч нуур байхгүй харин борооны ус, нэг бэсрэг булгаар тэжээгддэг тойром үлджээ (Зураг-3).




Зураг 2. Ходон голын эдгэрч байгаа хуучин голдрил.




Зураг 3. Цойцон нуурын шалны хөлд үлдмэл тойром.


Цойцон нуурын усны эзэлхүүн ба гүний хамаарлыг зураг –т үзүүлэв. Нуурын усны толио боломжит их түвшин 1539 м-т хүрэхэд усны эзэлхүүн ойролцоогоор 35 сая м³ байна. Нуурын усны түшин 1539 м-ээс дээшлэхэд баруун талд байрлах 0.41 км² толион талбайтай Жүрхэнт нуурыг усаар сэлбэж, Ходон (Буянт) голыг босгыг давж урсана.



Зураг 4. Цойцон нуурын усны толины түвшин, эзэлхүүний хамаарал.



Зураг 5. Цойцон нуурын ёроолын топо зураглал, усны толионы түвшин, өндөршилт.



Зураг 6. Нуурын ерөнхий байдал



Зураг 7. Ходон голын голдрил шилжсэн газар хэмжилт хийж байгаа нь. 2021 он

2021 оны 8-р сарын 9-нд 2017 оны хэмжсэн цэгээс ойролцоогоор 500 м-ийн доош сонгосон хөндлүүрт (51°21'59.0", 99°34'53.8") хэмжилт хийхэд 11.7 м³/с өнгөрөлттэй байлаа. Голын өргөн 58 м, дундаж гүн 51 см, үер өнгөрөөд 20 гаруй хоносон байв.

Хүснэгт 1. Бэлтэс, Ходон голын жилийн доторх урсацын хуваарилалт.

Сар	Бэлтэс гол		Ходон гол
	%	Q ₅₀ м ³ /с	Q ₅₀ м ³ /с
1	0.00	-	-
2	0.00	-	-
3	0.00	-	-
4	2.54	0.68	0.82
5	15.5	4.15	5.03
6	36.2	9.69	11.7
7	25.6	6.86	8.31
8	11.0	2.96	3.59
9	4.53	1.21	1.47
10	3.18	0.85	1.03
11	1.05	0.28	0.34
12	0.22	0.06	0.07
НИЙТ	100		

Хүснэгт 1. Ходон голын урсацын горимын үзүүлэлтүүд.

Гол	Ус хурах талбай км ²	Олон жилийн дундаж			
		Урсац м ³ /с	Модуль л/сек км ²	Хувьсалын коэффициент	
				Cv	Cs
Ходон	631	2.7	4.3	0.33	0.66

Дүгнэлт:

Дархадын хотгорт хур тунадасны хэмжээ 20-40мм-ээр багасч, агаарын температур бага зэрэг өссөн нь нуурын экосистемд шууд нөлөөлөл үзүүлэхгүй ч, цаашид сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай юм. Дархадын хотгорын нууруудын экосистемд өөрчлөлт орсноор орчны байдал доройтож, чийгийн хомсдол бий болж, бэлчээр эрс муудсан байна. Бэлчээрийн ургамлын бүрэлдэхүүн өөрчлөгдөж, хөл газрын зэрлэг ихээр ургах болсон. Хэдийгээр малын бэлчээрийн даац хэт алдагдаагүй ч, нүүр орчмын бэлчээр муудсанаас малчид Ходон гол руугаа ихэд түрж буух болсон тул голын орчинд сөрөг нөлөө үзүүлэх хандлагатай байна. Голын урсац багассан гэж нутгийн иргэд үзэж байгаа ч олон жилийн мэдээний дунджаар авч үзэхэд төдийлөн буураагүй. Нуурын доройтлоос улбаалан орчны экосистемд сөрөг нөлөө үзүүлж, цөлжилт нэмэгдэж, элсний нүүлт эрс хүчтэй болж байгааг харгалзан нуурыг сэргээх арга хэмжээ авах шаардлагатай.